



ДУЛААНЫ Ш ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2017 оны 04 сарын 11 өдөр

Дугаар Б/132

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн гэрээг ажилтны  
санаачилгаар цуцалж нэг удаагийн  
тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3.3 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоол, Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн Үйлдвэрчний эвлэлийн холбооны 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 85 тоот албан бичиг, Компанийн захиргаа, түүний дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан 2015-2017 онд хэрэгжүүлэх Хамтын гэрээний 3.1.2, 5.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Түлш дамжуулах цехийн дамжлагын машинч Рэгзэдмаа овогтой Дашдоржтой байгуулсан хөдөлмөрийн гэрээг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс цуцалж ажлаас чөлөөлсүгэй.

2. Эрчим хүчний салбарт 16 жил ажилласан Р.Дашдоржид 12288000 төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосугай.

3. Р.Дашдоржтой цалин хөлс, ээлжийн амралт, эд аж ахуйн тооцоо хийж дуусган нэг удаагийн тэтгэмжид зарцуулагдах 12288000 (арван хоёр сая хоёр зуун наян найман мянган) төгрөгийг ажилтны нийгмийн зардлаас олгохыг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга /Л.Доржхорлоо/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.ДАМДИНСҮРЭН